



WWF

MONGOLIA



МОНГОЛЫН ШУБУУ
ХАМГААЛАХ ТӨВ

ЦЭН ТОГОРУУ

Улаанбаатар 2020

ДАА 598
ННА 28.693.35
Г-234

Зохиолыг бичсэн:
Пүрэв-Очирын Ганхуяг (Монголын шувуу хамгаалах төв)

Зургийг:
Галмандахын Амарсанаа
Номын эхийг:
Хорлоогийн Балдандорж

ISBN: 978-9919-9565-8-5

Зуны амралт эхэлсэн тул Дулмаа охин сумын дотуур байрнаасаа гарч гэртээ ирэв. Дулмаагийн гэр сумаас ердөө 20 км зайд үзэсгэлэнт нуурын хажууд байдаг. Өвс ургамал сайхан ногоорч амжаагүй, гандуу шаргал харагдах хэдий ч үзэсгэлэнт цэн тогоруу нүүдлээсээ ирж нуурынхаа мөсийг гэсэхийг хүлээн хосоороо харагдах нь сэтгэл сэргэм үнэхээр сайхан.

Дулмаа өглөө эртлэн босч, ээжтэйгээ хамт үнээгээ сааж, зөөхийгөө машиндаж дуусаад яаран нуур руугаа гүйлээ. Олон зүйлийн нугас, эргийн шувууд ирж, нуур амь орсон мэт шувуудын дуу хаа сайгүй дуугарч жигтэйхэн сайхан байв. Энэ жил хос цэн тогоруу маань нуурынхаа зэгсэнд үүрлэх болов уу яах бол гэсэн бодол Дулмаагийн санааг зовоож байв.



“Гандуу өвөл болсон тул нуурын зэгсийг мал ихээр идэж өвөлжлөө, хоёр тогоруу маань энэ жил үүрлэж чадахгүй боллоо доо хөөрхий” гэж аавынх нь ярьсан яриа үргэлж бодогддог байв.

Дулмаа өглөө бүр нуурын эрэгт ирж хос тогоруугаа үүрлэсэн эсэхийг байнга хардаг байв. Ингэж бараг 14 хоног өнгөрч 5-р сарын дунд болов, тогоруунууд үүрлээгүй хэвээр л байв. Үүрлэх цаг хугацаа хэдийнэ болсон тухай Дулмаагийн гэрийнхэн бүгд ярьцгааж байв.



Нэгэн сайхан өглөө
Дулмаагийн ээж тугалаа
бэлчээрт гаргачихаад гэртээ
ирээд, хоёр тогорууны нэг нь
харагдахгүй байна, манай хоёр
үүрлэж эхэлсэн юм болов уу даа
хэмээв. Энэ үг Дулмаа охины
сэтгэлийг их хөдөлгөж, үхрийн
шаваасаа түүж дуусгалгүй
шууд гараад гүйлээ. Нээрээ
л ганц тогоруу нуурын захад
идээшиж байгаа харагдлаа.
Дулмаа гэртээ хариад энэ
өдрийг дэвтэртээ тэмдэглэв.
Учир нь, тогоруу өндөгөө 30
хоног дарж дэгдээхий болгодог
гэж аавынхаа ярьсныг тэрээр
сайн санаж байв. Ийнхүү Дулмаа
охины хувьд 30 хоногийн дараа
дэгдээхийнүүд өндөгнөөсөө
гарна даа хэмээн бас нэг
хүлээлт эхэллээ. “Шувууд үүрлэж
өндөгөө дараад эхэлсэн бол зэгс
рүү адуу, үхрээ хамаагүй оруулж
болохгүй үүрийг нь сүйтгэж
мэднэ” гэж Дулмаагийн аав
бодлогошронгуй хэлэв.



Энэ жилийн зуны амралтаар Дулмаагийн найз Халиунаа аймгаас ирэх болов. Халиунаа ирэх хугацаа болж сумаас машинаар тосохоор энэ өдөр Дулмаагийн аав сум руу явлаа. Халиунаа ирж Дулмаа тэр хоёр сонин сайхан ярилцаж гэрийн хаяанд үдэш болтол суув. Гэтэл дээгүүр нь маш олон шувууд нисэж хойд зүгрүү алсран холдов. Халиунаа үүнийг гайхаж асуухад “Нүүдлийн шувууд өдөр нууранд амраад шөнөөр нүүдлээ үргэлжлүүлдэг гэж аав минь хэлсэн” хэмээн Дулмаа хариулав....






Хотонд хурга, ишиг майлалдаж Дашдоржийнх энэ өглөө хөл хөдөлгөөн ихтэй байв. Дулмаа, Халиунаа нар хурга, ишигнүүдээ бэлчээрт гаргахгүй, эх сүргээс нь салгаж үлдээх гэж хотонд гүйлдээд завгүй байв. Үд орчимд тэд аргал түүхээр явлаа. Нууранд олон шувуу амар тайван байв. Үүнийг гайхсан Халиунаа “Өчигдөр орой маш олон шувууд хойшоо нүүсэн, гэтэл нууранд дахиад олон шувуу байна” гэхэд, Дулмаа “Өнөө өглөө шувууд нэмэгдэж ирсэн байх гэв. Учир нь энэ нуур нүүдлийн шувууд урт замдаа бууж амардаг чухал нуур шүү гэж нутгийн хүмүүс ярьдаг” гэж хэллээ.

Дулмаа нуурын захад идээшилж буй ганц тогорууг зааж энэ бол цэн тогоруу, манай энэ нуурын зэгсэнд жил бүр үүрлэдэг юм. Намайг бага байхад л ирдэг байсан гэв. Яагаад ганцаараа байгаа юм бэ гэж Халиунаа гайхан асуухад, Дулмаа “Нэг нь зэгсэнд үүрэндээ өндөгөө дарж байгаа. Өндөгөө 14 хоногийн өмнөөс дарсан, одоо 16 хоногийн дараа дэгдээхийнүүд гарна, тэд их өхөөрдөм, эцэг эхээсээ өөр, алтан шаргал зүстэй байдаг юм. Тэд ихэвчлэн 2 өндөг гаргадаг” гэж хэллээ.



Дулмаагийн аав Дашдорж нуурын захад сэрүүцэж буй хэсэг адууг холдуулахаар нуурын зүг хөдөллөө. Учир нь, нууранд байх адууны захад хос хошуу галуу 9 нялх дэгдээхийн хамт нэлээд сандарсан байдалтай тайван бус байна. Яагаад гэвэл, тэдний идээшилж, амарч хэвтдэг нуурын захад энэ хэсэг адуу өдөржин байрлав. Галууны гэр бүлийн тав тухыг алдагдуулж байгааг Дулмаагийн аав сайн мэдэх тул ийнхүү нуурын зүг явсан аж. Дашдорж гуай нуураас ирээд хоёр тогоруу хосоороо нуурын зэгснээс холгүй идээшилж байгаа тухай ярьлаа.





“Одоо ч өндөгнүүд нь хагарч дэгдээхий болсон байх учиртай даа” гэж аавынхаа хэлэхийг сонссон Дулмаа тэмдэглэлийн дэвтэрээ шүүрэн авч тогоруу өндөг дарж эхэлсэн өдрийг тоолов. Өндөг хагарах хугацаа болсон байна хэмээн Дулмаа охин чанга дуугаар хэлээд Халиунааг дагуулаад нуур руу гүйлээ.

Үнэхээр нуурын захад хос тогоруу хамтдаа идээшилж байв. Халиунаа, Дулмаа нар дэгдээхийнүүд байна уу? Чи харж байна уу? гэж бие биеэсээ байн байн асууна. Хэн нь ч дэгдээхий олж харсангүй, тэр орой хоёр охин гэртээ харьцгаав. Хоёр охиныг дэгдээхий харж чадаагүй тухай аав нь сонсоод “Нялх дэгдээхийнүүд жижигхэн учир тийм ч амар харагдахгүй ээ, өндөр өвсөнд олж харах хэцүү хөө, хэд хоногоос жаахан том болоод эцэг эхтэйгээ хамт зэгснээс хол тачир өвстэй газар руу гарч ирэх байх аа, тэр үед л та хоёрт сайн харагдана” хэмээв.

Халиунаад цэн тогорууны тухай олон зүйлийг мэдэх хүсэл улам их нэмэгдэж байв, учир нь Дулмаагийн аав Дашдорж олон жил мал маллан энэ нутагт амьдрахдаа олон сонирхолтой зүйлсийг харж өссөн тул хааяа тэдэнд амьтдын тухай маш сонирхолтой баримтуудыг ярьж өгдөг байлаа.

Дулмаагийн ээж, манай нууранд өмнө нь хоёр хос цэн тогоруу ирж үүрлэдэг байсан, нуурын хойно байгаа хатаж буй зэгстэй жижиг нууранд өмнө нь өөр хос цэн тогоруу үүрлэдэг байсан тухай дурсжээ. Харамсалтай нь, хур бороо багатай сүүлийн хэдэн жил энэ жижиг нуур усгүй болж зэгсийг нь мал идэж, шувуу үүрлэх аргагүй болсон ажээ. Гэхдээ зэгсийг нь хамгаалж чадвал бороотой жилүүдэд нуур сэргэж тогоруу маань буцаад ирэх байхаа гэж санаа алдан ярьлаа. Мөн тээр жилийн түймэрт энэ жижиг нуурын зэгс юу ч үгүй болтол шатаж түүнээс хойш сайн сэргэж чадахгүй байгаа тухай ч өгүүлжээ.



Хаврын улирал дуусч нүүдлийн үедээ нууранд бууж амардаг шувуудын тоо цөөрч, зөвхөн зусаж амардаг болон энэ орчимд үүрлэдэг нугас, галуу болон хун зэрэг шувууд л хосоороо дэгдээхийнүүдээ дагуулаад хөвж яваа харагдана. Зэгстэй нуур бол зөвхөн тогоруу гэлтгүй олон зүйлийн усны шувуудын үүрлэж, үр төлөө бойжуулдаг маш чухал амьдрах орчин болдог. Усны шувууд үүрлэх төдийгүй нуурын захаар идээшилж, ургамлаар хооллодог онцлогтой юм. Нуурын захад ногоон ширэг өвстэй газарт олон тооны галуу сүрэглэн бэлчих нь үнэхээр сайхан байдаг. Иймд шувуудын үржлийн үед нууранд мал олон тоогоор удаан хугацаатай байлгаж болохгүй, ингэх нь шувуудын амар амгалан байдлыг алдагдуулдаг хэмээн Дашдорж гуай байнга сануулдаг нь цаанаа ийм учиртай аж.

Зуны нэгэн нартай өглөө Халиунаа ганцаараа тугалаа тууж яваад нуурын захад хос тогоруу шаргал өнгөтэй шувуу дагуулан хамт идээшилж байгааг олж харжээ. Хэсэг зогсож харж байснаа гэрийн зүг тугалаа хариулан буцав. “Хос цэн тогоруу маань өөр жижигхэн хоёр шаргал шувуутай хамт байхыг харлаа” хэмээн Халиунаа хэнэггүйхэн ярив. Энэ үгийг сонссон Дулмаа “Тэр хоёр чинь дэгдээхийнүүд шүү дээ, би чамд дэгдээхийнүүд эцэг эхээсээ өөр зүстэй байдаг тухай хэлсэн шүү дээ” гэв.





Ийнхүү хос цэн тогоруу маань хоёр хөөрхөн дэгдээхийн хамт өдөр бүр нуурын захад тодоос тод гэгч нь харагддаг болжээ. Цэн тогоруу бол үнэхээр үзэсгэлэнтэй шувуу, тогоруугүй нуур “эзэнгүй айл шиг” гэж аавын минь ярьдаг юутай үнэн бэ гэж Дулмаа охин байн байн бодно.

Өдөр хоног өнгөрч дэгдээхийнүүд том болсоор байв. Цэн тогоруу 130 см өндөр, 120 см урт биетэй шувуу бөгөөд толгойн ар, шилэн хүзүүгээ дагаад нуруугаа хүртэл цагаан өнгөтэй тул энэ зүсээр нь бусад тогоруунаас амархан ялгаж болно. Хүзүүний өмнө хэсэг болон цээж, хэвлий нь хар зүстэй тул чанх өөдөөс харж зогсож байхдаа хав хар өнгөтэй харагддаг онцлогтой. Биеийн бусад хэсэг нь хар хөх, харин далавч, сүүл нь цайвар хөх зүстэй байдаг. Бусад тогорууны адил улаан нүдтэй бөгөөд нүдээ тойроод том улаан өнгөтэй.



Өдөр хоног өнгөрөх тусам тогоруунууд нуураас хол идээших нь их ажиглагдав. Учир нь дэгдээхийнүүд том болсон төдийгүй ойр зайд нисэж чаддаг болсон байв. Тогоруунууд юугаар хооллодог юм бэ? Байнга л газар тоншиж байх юм гэж Халиунааг асуухад Дулмаагийн аав “Тогоруу бол усны сээр нуруугүй амьтад болох шавж төдийгүй мэлхий, мөн ус намгархаг газар амьдардаг жижиг мэрэгч амьтадаар хооллохоос гадна хүчтэй хошуугаараа хөрсийг тоншиж ухаад эрвээхэйн авгалдайг түүж иддэг тухай судлаачид ярьсан” гэжээ. Ингэж хооллох нь тухайн нууранд тэжээл бологч амьтдын тоо толгой хэт олширч бохирдол үүсгэхээс сэргийлдэг сайн талтай гэсэн. “Тиймээс тогоруугаа хамгаалж чадвал нуураа хамгаалж байна гэсэн үг” гэж Дашдорж гуай хэллээ.

Удалгүй 8 дугаар сар ч дундаа орж халуун намраар цэн тогорууны гэр бүл өглөөдөө нуураас гарч нисээд хойд голын хөндийд өдөржин өнжөөд оройдоо зэгстэй нуурандаа ирж хоноглох нь ажиглагдлаа. Ингэж ойр зуур нисэж, шилжилт хөдөлгөөн хийх нь дэгдээхийнүүдэд маш чухал дадлага сургуулилт болдог. Тэд удалгүй урт удаан хол замд нүүх ёстой юм. Шувуудын нүүдэл бол улирлын шинжтэй хийгддэг томоохон шилжилт хөдөлгөөн учир залуу шувууд үүнд сайн бэлдэх хэрэгтэй болдог аж. Тэд нүүдлийн үедээ хүчтэй салхи, цасан шуурга зэрэг олон саад бэрхшээлтэй нүүр тулдаг учир эсэн мэнд өвөлжих газартаа хүрнэ гэдэг маш их тэвчээр, чадвар шаарддаг байна. Ийм учраас эцэг, өвгөд маань нүүдлийн шувуудыг нууранд нь тайван байлга гэж захиж ирсэн уламжлалтай юм.

Намрын дунд сар болж цэн тогорууны гэр бүл өглөө бүр чанга гэгч дуу гаргах нь олширчээ. “Тогоруунууд маань удахгүй нүүдлээ хийх цаг нь болж байгааг илтгэж байна” гэж Дулмаагийн аав ярив. “Миний ч гэсэн аймаг руугаа буцах цаг болж байна даа” гэж Халиунаа санаа алдан хэллээ.







Ийнхүү сурагчдын зуны амралт дусч шинэ хичээлийн улирал эхэлж байгаа тул Халиунаа аймгийн төврүү гэр рүүгээ харих, харин Дулмаа сумын төв рүү хичээлдээ явах өдөр ойртсоор байв. “Би ч бас цэн тогоруутайгаа адилхан гэрээ орхиод явах болох нь дээ” гэж Дулмааг хэлэхэд Халиунаа инээмсэглэж, “Тиймээ гэхдээ тогоруутайгаа хамт ирэх хавар дахиад л ирнэ шүү дээ” гэж хариу хэлэв.

Намрын налгар нэгэн өглөө Дулмаа, Халиунаа хоёрыг сумын төв хүргэж өгөхөөр Дашдорж гуай машинаа асаав. Дулмаагийн ээж савтай зөөхий мухлагнаасаа гаргаж Халиунаа, Дулмаа хоёрт өглөө. “Сайн сураад ирэх хавар дахин ирээрэй” гэж хэлээд Халиунаагийн духан дээр үнсэв.

Тэднийг машинтайгаа нуурын хойгуур өнгөрч явтал хос тогоруу дэгдээхийнүүдээ дагуулан өмнө зүгийг чиглэн нисэж байгааг Дулмаа, Халиунаа хоёр хараад тогоруунууд маань нуураа орхиод нүүж байна гэж зэрэг шахуу хашгирлаа. Дулмаагийн аав тогорууны зүг хараад “Дэгдээхийнүүд нь мундаг болжээ, сайн нисэж байна, энэ хэд маань алзахгүй ээ хөө, сайн яваад ирэх хавар буцаад ирнэ шүү дээ” гээд санаа алдав.

Энэ үед нуур маань үнэхээр “эзэнгүй айл мэт” харагдаж байв. Дулмаа “Сайн яваад ирэх хавар заавал ирээрэй, нуурыг чинь бид хамгаалж байх болноо” гэж амандаа шивнэн машины цонхоор удаан гэгч нь ширтсээр сумын зүг явлаа.



ХҮҮХДҮҮД ТА НАРЫНХАА МЭДЛЭГТ

Дэлхий дээр 15 зүйлийн тогоруу байдгаас Монгол оронд 6 зүйлийн тогоруу бүртгэгдсэн байдаг. Тэдгээрийн нэг бол цэн тогоруу юм. Цэн тогоруу нь Монгол орны төв болон зүүн бүсийн гол, нууруудаар тархсан шувуу бөгөөд намар өмнө зүг 2,300 км нүүж Хятадын Пояанг нууранд хүрч өвөлждөг байна. Тэр нууранд Лотус буюу Бөлбөө хэмээх нэгэн зүйл ургамлаар түлхүү хооллож өвөлждөг тухай судлаачид дурдсан ажээ. Цэн тогоруу нь дэлхийд ховордсон төдийгүй Монгол орны “Улаан ном”-д орсон нэн ховор шувуу юм. Дэлхий дээр ердөө 7,000 орчим цэн тогоруу үлдсэн гэж судлаачид үнэлсэн байдаг.

Монгол орон бол цэн тогорууны үүрлэдэг, үржлийн гол нутгуудын нэг. Тогорууны гол үүрлэдэг орчин нь зэгс юм. Цэн тогоруу зэгсэнд голчлон үүрлэх хэдий ч их устай орчинд үүрлэж чаддаггүй, учир нь дэгдээхий нь өндөгнөөсөө гараад эцэг, эхээ дагаад чөлөөтэй алхаж чадах орчин чухал байдаг. Иймд голын хөндийд гүехэн усаар хүрээлэгдсэн дов сондуул бүхий чийглэг газар, мөн бургасан дунд багахан тогтоол ус бүхий довцогтой орчинд өвсөөр үүр засаж үүрлэдэг онцлогтой. Тиймээс та энэ тогорууг зэгсгүй гол, нууранд ч харах боломжтой юм.

